



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/88

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулий 29 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотхон 30 айлын амины орон сууцны зориулалттай “Бат дайчин” ХХК /4073886/-ийн эзэмшлийн 6000 метр квадрат газраас 73 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Баярхүүгийн Саруултөгс /пи94120106/-д шилжүүлж, амины орон сууцны зориулалтаар, хаягийг Батмонгол 3 дугаар гудамжны 307 тоот болгон 15 жилийн хугацаагаар,
2. Жаргалант сумын Буянт багийн Эко хорооллын 3 дугаар гудамжны 23 в тоот хашааны зориулалттай Ядмаагийн Буянтогтох /пэ65063003/-ийн эзэмшлийн 526 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Цэдэнсодномын Чинзориг /РЮ66022568/-т шилжүүлж, хаягийг Хөгжлийн 1 дүгээр гудамжны 140 тоот болгон 1 жилийн хугацаагаар,
3. Магсаржав багийн Амарсанаагийн 2 дугаар гудамжны 200а тоот худалдаа, үйлчилгээний зориулалттай Аманбайгийн Жексенбай /ПЛ87071217/ -ийн эзэмшлийн 36 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Бямбаахүүгийн Эрдэнэтуяа /ПЮ95122103/-д 13 жилийн хугацаатайгаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

4.Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

5. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэдтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ